



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2025 оны 09 сарын 30 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.4, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9.2.2 дахь заалт, 9.4, 9.7 дахь хэсгийг үндэслэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

О.Саранчулуун

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсгийн гишүүд:

А.Ариунзаяа

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

Б.Бейсен

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

Д.Ганмаа

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

Т.Мөнхсайхан

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

Ц.Мөнхтуяа

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

М.Сарнай

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

Л.Энхнасан

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

Д.Энхтуяа

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

М.Энхцэцэг

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

С.Эрдэнэбат

-Монгол Улсын Их Хурлын гишүүн


2. Ажлын хэсгийн хяналт шалгалт хийх үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулж ажиллуулахыг Ажлын хэсэг (О.Саранчулуун)- т зөвшөөрсүгэй.

4. Холбогдох санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг (О.Саранчулуун)-т даалгасугай.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.НАЙДАЛАА



Монгол Улсын Их Хурлын Байнгын
хорооны 2025 оны 09 сарын 30-ны өдрийн
02 дугаар тогтоолын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

1.1. Ажлын хэсгийн зорилго:

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, тодорхой чиглэлээр санал, дүгнэлт боловсруулах зорилготой.

1.2. Зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1. Монгол Улсын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, сэтгэцийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэж байгаа байдалд дүн шинжилгээ хийнэ.

2. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр төсөв санхүүжилтийг судалж, Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуульд заасан хүрээнд хяналт шалгалт явуулна.

3. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг судалж цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлно.

4. Ажлын хэсэг шаардлагатай гэж үзвэл хуулийн хэрэгжилтийг хангах талаар Улсын Хурлын болон Байнгын хорооны тогтоолын төсөл боловсруулж, хуульд заасны дагуу шийдвэрлүүлнэ.

1.3. Хугацаа, үе шат

Ажлын хэсэг 2025 оны 10 дугаар сарын 01-нээс 2025 оны 12 дугаар сарын 15 өдөр хүртэл хугацаанд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Үүнд:

- Засгийн газар, яам, агентлаг, холбогдох нэгж, албан тушаалтнаас нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой баримт, тоон мэдээлэл цуглуулах, тайлан мэдээ гаргуулах;

- хууль хэрэгжүүлэгч субъектээс тодруулга авах, тайлбар сонсох;

- хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр санал, дүгнэлт боловсруулах;

- үндэслэлтэй бол тухайн хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолын төсөл боловсруулах үе шаттайгаар ажиллана.